

БАТЛАВ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ЭНХЦЭЦЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм/БНбаД/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх ирэх материал:

- Барилга угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийх фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэнэ.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Асгат сумын төвийн дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг батлагдсан ажлын зураг төсөл, тоо хэмжээний дагуу хийж гүйцэтгэнэ.

Дээрх ажил дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

1. Зуухны барилга
2. Зуухны барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ
3. Зуухны барилгын гадна цахилгаан хангамж
4. Төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээ

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэсэн заалтын баталгаа гаргаж өгнө.

Барилга угсралтын ажлын гэрээг баталгаажуулсны дараагаар аймгийн ГХБХБГ-аас “Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл”-ийг заавал авч, ажлыг эхлүүлнэ.

Угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНбаД 3.05.03-95, БД43-101-03, БНБД 3.05.06-85 техник аюулгүйн норм дүрмийг мөрдлөг болгоно.

Шугам хоолойг угсарч дууссаны дараа шугам хоолойг норм дүрмийн дагуу усаар шахалт хийж шалгах ба ил, далд ажлын акт үйлдэн холбогдох мэргэжлийн хүмүүст хүлээлгэн өгнө.

Шугам хоолойн ажлын угсралтын явцад эвдэрсэн ногоон байгууламж, авто зам, явган хүний замыг сэргээн засварлана.

Газар шорооны ажил эхлэхийн өмнө холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авна.

Угсралтын ажлыг зурагт заасан технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэх ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсгийг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч

байгууллагад албан бичгээр гаргах бөгөөд захиалагч хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Магадлашгүй ажлыг хэрхэн, ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техникийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженерт танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу АЗДТГ, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гаргана. Зөвшилцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлыг санхүүжүүлэхгүй болно.

Батлагдсан ажлын зураг төсөл, норм дүрэм, технологийн шаардлагыг зөрчсөн, техникийн тодорхойлолд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчид төлөөлөл, захиалагчийн техник хяналтын баг, холбогдох Улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэлх арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн  Б.Мөнхсүлд